



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/377

Зуунмод

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, шийдвэр, зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, Коронавируст халдвар /Ковид-19/-ын дараах нөхөн сэргээх, сэтгэл заслын зөвлөгөө, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр аймгийн Засаг дарга, Баянхангай, Аргалант, Лүн, Эрдэнэсант сумдын Засаг дарга, Шүрэн Ундарга НҮТББ-ын гүйцэтгэх захирал нарын хооронд байгуулсан гэрээний дагуу сургалтын төлбөрийг гүйцэтгэгч байгууллагад гэрээ, нэхэмжлэх, санхүүгийн бусад баримтыг үндэслэн олгосугай.

2. Сургалтын зардалд шаардагдах 8,250,000 (найман сая хоёр зуун тавин) төгрөгийг төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулж ажиллахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР